**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/300 Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан Цэдэндоржийн Наранцэцэгийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурьдсанаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан байгууллагатай гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Ё.Мөнх-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан Батчулууны Энхчулуун-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 18-ны А/136 дугаар захирамжийн Цэдэндоржийн Наранцэцэг-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Р.ЭНХТӨР

сумын Засаг даргын 2025 оны
..10.. дугаар сарын ..20..-ны өдрийн
А/300..... дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлсэн болон шилжүүлэн авсан иргэний жагсаалт

| Шилүүлэн авч буй АА-н нэгж, иргэний нэр | Регистерийн дугаар | Газрын хэмжээ /га/ | Хугацаа /жил/ | Газрын байршил | Зориулалт | Нэгж талбарын дугаар | Шилжүүлсэн АА-н нэгж, иргэний нэр | Шилжүүлсэн үндэслэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Баянцогт Батчулуун Энхчулуун | СЭ78050411 | 1.0 | 15 | 2-р баг, Тэнхлэг | Амралтын газар | 2314003643 | Цэдэндорж Наранцэцэг | Өөрийн хүсэлтээр |
| Дүн | | 1.0 | | | | | | |